



Төрийн албаны зөвлөлийн  
2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн  
220 дугаар тогтоолын 25 дугаар хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хувь тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт авччапт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр,  
огноо:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хууль.

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Улсын бүртгэлийн ерөнхий газар

Албан тушаалын нэр:

Ахлах мэргэжилтэн /хуулийн этгээдийн баримтын архив хариуцсан/

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Газрын нэр:

Улсын бүртгэлийн нэгдсэн архив

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо, Цагдаагийн гудамж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын байр

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Салбарын бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг тайллагнах хүрээнд хуулийн этгээдийн баримтын архивын хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, удирдлагыг мэргэшлийн зөвлөгөө, мэдээллээр хангах, гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Нэгжийн түвшинд салбарын бодлого, хууль, тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангуулах, тайлагнах, олон нийтэд сурталчлахад дэмжлэг үзүүлэх;
- 2.Хуулийн этгээдийн баримтын архивын хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах ажлыг хариуцан зохион байгуулах, өдөр тутмын хяналт тавих;
- 3.Улсын бүртгэлийн нэгдсэн архивын дотоод ажлыг хариуцан гүйцэтгэж, тайлан мэдээг нэгтгэн гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, тайлагнах;
- 4.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож, төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлэх, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-X Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Нэгжийн чиг үүрэгт хамаарах салбарын бодлого, хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын биелэлтийг хангуулах, нэгжийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг багаар гүйцэтгэж, үр дүнг нэгтгэн тайлагнах;	-Хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хугацаанд нь үнэн зөв тайлагнасан байна.	Г, Х
	2.Нэгжийн чиг үүрэгт Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, холбогдох тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох саналыг боловсруулах, бодлогын болон эрх зүйн баримт бичгийн төсөлд өгөх саналыг нэгтгэн удирдлагад танилцуулж, хүргүүлэх;	-Үндэслэл бүхий санал боловсруулж шийдвэрлүүлсэн байна.	Г
	3.Эрх бүхий байгууллагаас өгсөн зөвлөмж, шаардлагын биелэлтийг тайлагнах, мэдээлэл боловсруулах, хуульд заасны дагуу төр, хуулийн этгээд, хүний хувийн мэдээллийг хамгаалах;	-Зөвлөмж шаардлагын хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Г, Х
	4.Хууль тогтоомжоор хүлээсэн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх, удирдлагаяас өгсөн чиглэлийн дагуу холбогдох албан тушаалтанд шаардлагатай мэдээллийг нэгтгэн өгөх, мэдээлэл солилцох, үр дүнг тайлагнах;	-Хуулийн дагуу хамтран ажиллаж, мэдээлэл солилцсон байна.	X, Ш
	5.Улсын бүртгэлийн болон архив,	-Сурталчилгааны тоо	

	албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, нэгжийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээллээр хангах үйл ажиллагааг зохион байгуулах;	-хуульд нийцсэн, нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл	Г
	6. Цахим сангийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, аливаа халдлага илэрсэн тохиолдолд холбогдох нэгжид мэдэгдэх, зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	-Халдлага илэрсэн тохиолдолд холбогдох газарт шуурхай мэдэгдэн, арга хэмжээ авч ажилласан.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Архивын сан хөмрөгийн баримтын улсын бүртгэл хөтөлж, тэдгээрийн агуулга, бүрэлдэхүүн, байршлын талаар мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах ажлыг хариуцан зохион байгуулах, тайлагнах;	-Төрийн архивын сан хөмрөгт хамаарах баримтын бүрэлдэхүүн, өөрчлөлт хөдөлгөөний талаарх мэдээ тайлан үнэн зөв байна.	Г
	2. Архивын баримтын хамгаалалт, хадгалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалт түүнтэй холбогдолтой ажлыг хариуцан зохион байгуулах, биелэлтийг хянах;	-Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа сайжирч, архивын тухай хуульд заасан баримтаар сан хөмрөгөө нөхөн бүрдүүлсэн байна.	Г, Х
	3. Хөтлөх нэрийн жагсаалтын дагуу архивд хүлээн авсан баримтыг ангилах, төрөлжүүлэх, сэлбэн засах, сэргээн шинэтгэх, няглан шалгалт хийх, зориулалтын байранд, зохих горимын дагуу хадгалах, баримтын бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллах, хяналт тавих;	-Архивын аюулгүй байдлын баталгаа хангагдсан байна.	Г, Х
	4. Эх нотлох баримт бичгийн цахим архивын санг үүсгэх ажилд хяналт тавьж, мэдээллийн нэгдсэн сангаас лавлагaa, хуулбар олгох ажлыг хариуцан зохион байгуулах, хянах;	-Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь мэдээлэл нь цаасан эх хувьтай адил байна.	Г, Х
	5. Хуулийн этгээдийн баримтын архивын тоо бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт тавих, тооллого хийх ажлыг хариуцан зохион байгуулах, тайлагнах;	-Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
	6. Төрийн архивын дэргэдэх	-Хууль тогтоомж,	Г

	БНШАЗК-оор холбогдох асуудлыг хэлэлцүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх.	дүрэм, журамд нийцсэн байна.	
З дугаар зорилтын хүрээнд	1.Нэгжийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийн тайланг нэгтгэн танилцуулж, холбогдох нэгжид хүргүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах;	-Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, ажил үйлчилгээ үр дүнтэй хэрэгжиж, үнэн зөв	Г
	2.Улсын бүртгэлийн архивын болон захиргааны статистик мэдээ, тайланг нэгтгэн гаргах, холбогдох газарт хүргүүлэх;	-Мэдээ тайлан, үнэн зөв, бодитой байна.	Г
	3.Албан хаагчдыг мэргэшлийн зөвлөгөөгөөр хангах, дотоод сургалт зохион байгуулах, тайлагнах;	-Сургалтад бүрэн хамрагдсан байна.	Г
	4.Нэгжийн албан хаагчдын өдөр тутмын ажиллагааг уялдуулан зохицуулах, чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, багийн гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулах, хөгжүүлэх, албан хаагчдын зан төлөв, хандлагыг зергээр өөрчлөх, үр дүнг тооцох, дотоод ажлыг нэгтгэн зохион байгуулах, үүрэг даалгаврын биелэлтийг гаргах;	-Дотоод ажил зохион байгуулалт сайтай болсон байна.	Г, Х
	5.Ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хуулиар тогтоосон хориглолт, хязгаарлалт болон хөдөлмөрийн дотоод журам, бусад дүрэм, журмыг мөрдүүлэх, мөрдэх, хамт олныг манлайлах;	-Зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан байна	Г
	6.Нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж, эрсдэлийн үнэлгээ хийх, бууруулах арга хэмжээний талаар санал боловсруулах, удирдлагыг мэдээллээр хангах.	-Эрсдэлийн үнэлгээ хийж, бууруулах арга хэмжээ авч ажилласан байна.	Г, Х
	1.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнах;	-Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан, үнэлгээг гаргасан байна.	Г
	2.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг	-Төрийн албаны нэр хүндийг	

4 дүгээр зорилтын хүрээнд	журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлэх;	эрхэмлэн дээдлэж, үүрэг даалгаврыг биелүүлсэн байна.	Г
	3.Өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх;	-Мэргэжлийн болон хувь хүний мэдлэг, боловсрол ур чадвараа тогтмол дээшлүүлэн ажилласан байна.	Г, Ш
	4.Өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэж, мэдээ тайланг сар бүр гаргах, мэдээлэх;	-Өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэгдсэн байна.	Г
	5.Албан хэргийг стандарт, холбогдох журмын дагуу хөтөлж, анхан шатны баримт бүрдүүлэн хөтлөх нэрийн жагсаалтын дагуу байгууллагын архивд шилжүүлэх;	-Албан хэрг хөтөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байна.	Г
	6.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелүүлэх, цаг үеийн арга хэмжээнд оролцох, эргэн мэдээлэх.	-Үүрэг даалгаврын дагуу ажил үүргийг хийж гүйцэтгэсэн байна.	Г

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА:

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй		
Мэргэжил	Эрх зүй /0421/ архив судлал /0322		
Мэргэшил	-		
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.		
Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- мэдээлэлд тулгуурлан салбарын үйл ажиллагаанд дүн шинжилгээ, харьцуулсан судалгаа хийх;</li> <li>- бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулах;</li> <li>- мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> <li>- судалгааны үр дүн, шийдлийн хувилбаруудын үр дагаврыг харьцуулан үнэлэх;</li> <li>- бусад.</li> </ul>		
Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах;</li> <li>- өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг</li> </ul>		

		<ul style="list-style-type: none"> <li>- боловсруулж, хариуцах;</li> <li>- шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах;</li> <li>- хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах;</li> <li>- аливаа харилцааг хэрэгжүүлэх арга замыг хууль тогтоомжид тусгах санал боловсруулах;</li> <li>- асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;</li> <li>- гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах.</li> </ul>
Үр чадвар	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх;</li> <li>- нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа үйлчилгээг нэвтрүүлэх, чиглүүлэх, албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих;</li> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;</li> <li>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- байгууллага, нэгжийн үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх</li> <li>- гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа хамт олны саналыг тусгах, үр дүнд чиглүүлэх.</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- байгууллагын үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах;</li> <li>- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх;</li> <li>- компьютерын хэрэглээний программ хангамжийг эзэмшиж, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэн ажиллах;</li> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;</li> <li>- багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах;</li> <li>- харилцааны орчин үеийн арга технологийг ашиглах, мэдээллийг шуурхай хүргэх.</li> </ul>

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЬЕКТ:

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:  
Улсын бүртгэлийн нэгдсэн архивын дарга

<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> <ul style="list-style-type: none"> <li>- ахлах архивч-2</li> <li>- мэргэжилтэн-6</li> <li>- судлаач архивч-11</li> </ul>	<u>Бусад харилцах субъект:</u> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын адил түвшний албан тушаалтан;</li> <li>- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын адил түвшний албан тушаалтан;</li> <li>- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.</li> </ul>
	Нийт: 19

**V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:**

Албан тушаалын тодорхойлолтыг  
боловсруулсан:

Албан тушаал:  
**ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА**  
Г.ЦОЛМОН  
2023 оны 6 дугаар сарын 20 -ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг  
хянаж, батлах зөвшөөрөл олгосон  
байгууллагын шийдвэр:

Байгууллагын нэр:  
**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

Шийдвэрийн огноо: 2023.06.07  
Дугаар: 220

**VI.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:**

Байгууллагын нэр: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023.06.30

Дугаар: A/1834

(тамга/тэмдэг)

ДАРГА..... Д.ДЭЛГЭРСАЙХАН

2023 оны 6 дугаар сарын 30 -ны өдөр